

“ЭМ ЭН ДИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 04 сарын 28-ны өдөр

Дугаар:.....

Улаанбаатар хот

“ЭМ ЭН ДИ”ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Улаанбаатар хот, Хан уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж, Жаргалан хотхон 24-р хаус 2022 оны 04 дугаар сарын 28-ны өдөр 15:00 цагт хийв.

Хурлын дарга Н.Ганчимэг: “ЭМ ЭН ДИ”ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг тооллогын комиссын дарга Б.Сүнчигмаа хурлын ирцийг талаар мэдээлэл өгнө үү.

Хурлын дэг:

Хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.

- Компанийн 2021 оны бизнесийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын тайланг танилцуулах
- Компанийн ноогдол ашиг тараахгүй тухай ТУЗ-ын гаргасан тогтоолын танилцуулга
- Компанийн 2022 оны үйл ажиллагааны зорилтын тухай
- Компанийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай
- Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааг хуваах замаар, хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай санал

- Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт хариулт / хүн тус бүр 3 минут/
- Тооллогын комисс санал өгөх журмыг тайлбарлах /3 мин/
- Санал хураалт явуулах /20 минут/
- Тооллогын комиссоос санал тоолох үйл ажиллагааг явуулах /20 минут/
- Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах /5 минут/
- Хурлаас гарах шийдвэрийг хурлын дарга танилцуулах /5 минут/
- Хурлыг хаах

Та бүхэнд хэлэлцэх асуудлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл тараасан материалд байгаа.

Хурлын ирц:

Тооллогын комиссын шийдвэр: 97360 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй буюу 84 хувьцаа эзэмшигч байгаагаас 72,265 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 72 % хувийг эзэмшигч 4 хувьцаа эзэмшигч хуралд оролцож байна.

Иймд Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт болон компанийн дүрэмд заасныг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.

Хэлэлцсэн нь:

1. Компанийн 2021 оны бизнесийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан

Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Н.Отгон-Од

Өнгөрсөн онд татварын мэргэшсэн зөвлөх болох СИ ЭС АЙ АУДИТ ХХК-тай хамтран ажиллаад үйл ажиллагаанд хөндлөнгийн аудитын дүгнэлтээр баталгаажуулж хамтран ажиллахаар 5 жилийн гэрээ байгуулсан болно.

НББ-ийн дансны нэгдсэн зааврын дагуу үндсэн үйл ажиллагаагаа тохируулан баланс болон орлого, зарлага санхүүгийн жилийн татвар ноогдох тайлангаа Монгол улсын аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хууль бусад холбогдох хуулийн хүрээнд бэлтгэн тайлагнадаг.

Санхүүгийн тайлангаа НББ-ийн аккурэл суурьд үндэслэн бэлтгэдэг ба холбогдох хуулийн дагуу улирлын тайлангаа дараа сарын 20-ны дотор, жилийн тайлангаа дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор баталгаажуулан Сангийн яам болон Татварын хэлтэс, МХБ, СЗХ тус бүр хүргүүлэн ажиллаж байна.

Дэлгэрэнгүйг аудитын дүгнэлтээс үзнэ үү.

Та бүхэнд санал, хүсэлт байна уу?

Бүх гишүүд: Асуух асуулт байхгүй.

2. Компанийн санхүүгийн үйл ажиллагааны тайлан, аудитын тайлан, ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн ноогдол ашиг тараахгүй байх тухай танилцуулга

Хэлэлцсэн нь:

ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэсний дагуу Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, 46-р зүйлийн 6 дахь заалт болон ТУЗ-ийн 2022 оны 02 дугаар сарын 8-ны өдрийн хурлын шийдвэрийг танилцуулж, санал нэгтгээгээр ноогдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн тогтоолыг танилцуулж, гишүүд дэмжив.

Та бүхэнд санал, хүсэлт байна уу?

Бүх гишүүд: Асуух асуулт байхгүй.

3. Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал, зардлын төсвийн тухай Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Н.Отгон-Од

Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг үргэлжлүүлэн ажиллах бөгөөд компанийн үйл ажиллагаанаас шалтгаалан ТУЗ-ын хурал зарлаж, шийдвэрлэнэ.

4. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тухай

Компанийн үйл ажиллагаа идвэхижүүлэх зорилгоор одоо байгаа хувьцааг хуваах замаар нэмэгдүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа эхний ажлууд төлөвлөгөөний дагуу хийгдсээр байна.

Та бүхэнд санал, хүсэлт байна уу?

Бүх гишүүд: Асуух асуулт байхгүй.

5. Компанийн 2022 оны үйл ажиллагааны зорилтын тухай

Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Н.Отгон-Од

Говь алтай аймгийн Тайшир суманд уул уурхайн операторын үйл ажиллагааг эрхлэхээр төлөвлөгөөний дагуу ажиллаж, талбайд кэмп барих ажилтан ажилд авахаас үйл ажиллагаагаа эхлэхээр төлөвлөн эхний ажлууд хийгдсээр хийгдэж байгаа.

Та бүхэнд санал, хүсэлт байна уу?

Бүх гишүүд: Асуух асуулт байхгүй.

6. Компанийн ТУЗ-ийн гишүүдэд өөрчлөлт оруулахыг Гүйцэтгэх захирал Н.Отгон-Од танилцуулав.
Үүнд:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс Бадамсамбуугийн Баярсайхан-ыг чөлөөлж, Н.Гансувдыг томилох, мөн Хараат бус гүшүүн Оюунгэрэлийн Мөнхдалай-г чөлөөлж, Н.Ганбаатар нарыг тус тус оруулах саналтай байна.
- Гишүүд: Бадамсамбуугийн Баярсайхан-ыг чөлөөлж, Н.Гансувдыг томилох, мөн Хараат бус гүшүүн Оюунгэрэлийн Мөнхдалай-г чөлөөлж, Н.Ганбаатар нарыг тус тус оруулах татгалзах зүйлгүй гэж хувьцаа эзэмшигчид зөвшөөрөв.

Компанийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах

1. Намсрайн Отгон-Од
2. Пионг Чунг Фах (Piong Choong Fah)
3. Чунг Чии Иенн (Chung Chee Yenn)
4. Лю Вен Тейк (Lew Wen Teik)
5. Намсрайн Ганчимэг
6. Н.Гансувд

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр:

1. Цэрэндоржын Болд
2. Н.Ганбаатар
3. Баяр-эрдэнэгийн Сарнай тус тус томилож бүрэн эрхийг сунгахаар боллоо.

ТУЗ-ийн даргаар Намсрайн Ганчимэг-ийг, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Батсүхийн Эрдэнэтуяа нарыг үргэлжлүүлэн ажиллахаар тогтов.

Хэлэлцсэн нь:

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээллийг хавсралтаар танилцаж гишүүд санал нэгтгээгээр дэмжиж тогтоолоор нэр дэвшүүлэх, аудитын хороо, цалин урамшуулалын хорооны гишүүдийг сонгохыг хавсралтаар баталсугай.

Ингээд санал хураалтаа эхлүүлье.

Санал хураалт:

1. Компанийн 2021 оны бизнесийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн 72%-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлагдлаа.
2. Компанийн санхүүгийн үйл ажиллагааны тайлан, аудитын тайлан, ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн ноогдол ашиг тараахгүй байх шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн 72%-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлагдлаа.
3. **Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал, зардлын төсвийг үйл ажиллагаанаас хамааран тухайн үед шийдвэрлэхээр 72%-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлагдлаа.**
4. Компанийн үйл ажиллагаа идвэхижүүлэх зорилгоор одоо байгаа хувьцааг хуваах замаар нэмж хувьцаа гаргахыг Төлөөлөн удирдах зөвлөлд санал оруулан тухай үед Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржийн журмын дагуу нэмэгдүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгон 72%-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлагдлаа.
5. Компанийн 2022 оны үйл ажиллагааны зорилтын **хүрээнд** Говь алтай аймгийн Тайшир суманд уул уурхайн операторын үйл ажиллагааг эрхлэхээр төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Мөн компанийн хувьцаа нэмж гаргах ажлыг эхлүүлэхээр төлөвлөж ажиллахыг хувьцаа эзэмшигчдийн 72%-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлагдлаа.
6. **Компанийн ТУЗ-ийн гишүүдийн эрхийг сунгахыг хувьцаа эзэмшигчдийн 72%-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлагдлаа.**

Үүнд:

“ЭМ ЭН ДИ” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүдээр:

№	Нэр дэвшигч	Саналын тоо	Хувь
1	Piong Choong Fah	72,265	72%
2	Chung Chee Yenn	72,265	72%
3	Lew Wen Teik	72,265	72%
4	Н.Отгон-Од	72,265	72%
5	Намсрайн Ганчимэг	72,265	72%
6	Н.Гансувд	72,265	72%

б. “ЭМ ЭН ДИ” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүдээр:

№	Нэр дэвшигч	Саналын тоо	Хувь
1	Цэрэндоржын Болд	72,265	72%
2	Н.Ганбаатар	72,265	72%
3	Баяр-эрдэнэгийн Сарнай	72,265	72%

Хурлын шийдвэр:

Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

- Компанийн 2021 оны бизнесийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах
- Компанийн санхүүгийн үйл ажиллагааны тайлан, аудитын тайлан, ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн ноогдол ашиг тараахгүй байх тухай танилцуулга
- Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал, зардлын төсвийн тухай
- Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тухай
- Компанийн 2022 оны үйл ажиллагааны зорилтын тухай
- Компанийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгав

Хурал 2021 оны 04 дугаар сарын 28-ны өдрийн 18 цаг 00 минутанд дуусав.

БАТАЛСАН:

Хурлын дарга:

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Нарийн бичгийн дарга:



Н.ГАНЧИМЭГ

Б.ЭРДЭНЭТУЯА